

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: СОНГОХ ДААЛГАВАР**Санамж:**

1. Эхийг анхааралтай уншиж, ойлгоод даалгаврыг гүйцэтгээрэй.
2. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.
3. Эхээс сонгож авсан үг, өгүүлбэрийг эхийн утга санаатай холбож ажиглаарай.
4. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой. (Даалгавар бүр 2 оноотой)

Өвөл

Алсын салхин жихүүн амьсгалаар тас няс хийхэд
 Алтан дэлхийн уул тал мөнгөн хуягийг өмсөнө
 Өвлийн шөнө тэнгэрийн одон оч мэт гялалзахад
 Уудам талд жинчин хүний дуулах яруу
 Өндөр уулсын оройд будан хүдэн зугаацаад
 Өргөн талын хөндий нүд гялбам мэлцийхэд
 Бэлчээрт гарсан малууд соргог үсийг гялалзуулан буцахад
 Идэр залуу малчин түүнийг хураан исгээнэ
 Өндөр газрын хүйтэн тасхийм тасхийм, ясхийм ясхийм
 Монголын залуус нүүртээ цогтой, нүдэндээ галтай
 Зургаан мичид орой дээр зулын гэрэл хажууд
 Хөгшид өвгөд галыг базаан, хуучин үгсийг ярилцана
 Өвөл, хавар, зун, намрын дөрвөн улирал
 Уул, усан, наран, саран лугаа нөхөрлөнө
 Хүн бүр өтгөсийг үдэж, нялхсыг угтан
 Мянга мянган жил өчүүхэн ч чөлөө завгүй (Д.Нацагдорж)

1. Эх нь тоочимж болохыг баталсан хэсгийг олоорой.
 - A. Хэрэг явдлын бодомжийн харьцаанаас шинэ дүгнэлт гаргажээ.
 - B. Агуулга нь баримт жишээнд тулгуурлажээ.
 - C. Шалтгаан, үр дагавар, дүрэм тодорхойлолтод тулгуурлажээ.
 - D. Юмс үзэгдлийн гол шинжийг нарийн дэс дараалалтай зураглан бичжээ.
 - E. Хэрэг явдлыг өнгөрсөн, одоо, ирээдүй гурван цагт хүүрнэн бичжээ.
2. **“Хуучин үгсийг ярилцана.”** гэсэн өгүүлбэрийн өгүүлэхүүнийг анхааруулах өгүүлбэрийн өгүүлэхүүн болгон хувиргасан хэсгийг олоорой.

A. ярилцлаа	B. ярилцав уу	C. ярилцъя даа	D. ярилц	E. ярилцаач
-------------	---------------	----------------	----------	-------------
3. Угсруулах аргаар холбогдсон холбоо үгийг олоорой.

A. Тасхийм тасхийм	B. Будан хүдэн	C. Хөгшид өвгөд
D. Зургаан мичид	E. Уул тал	
4. **“Алтан дэлхийн уул тал мөнгөн хуягийг өмсөнө.”** гэсэн өгүүлбэрийг шууд утга санаагаар хувиргасан хэсгийг олоорой.
 - A. Явган шуурга өргөн талаар цасан манан татуулна.
 - B. Цаст цагаан шилүүдийн ар хормой болсон хөвч нутгийг бүрэнхий нөмөрлөө.
 - C. Энгэр нөмрийн цас нимгэнтэй газраас үдийн хэрд үл мэдэгдэх уур савсана.
 - D. Уул нурууг бүрхсэн хунгар цасны хасын өнгө алмаазын адил гилтгэнэнэ.
 - E. Эргэн тойрны газар нутаг цасаар хүрээлэгджээ.
5. Дараах өгүүлбэрүүдээс эхийн санаанд холбогдолгүй хэсгийг олоорой.

A. Холхи нар ойртож хасын цас хайлахад	B. Уудам талд жинчин хүний дуулах яруу
C. Алсын салхи жихүүн амьсгалаар тас няс хийхэд	D. Зургаан мичид орой дээр, зулын гэрэл хажууд
E. Өндөр газрын хүйтэн тасхийм тасхийм, ясхийм ясхийм	

6. **“Монголын залуус нүүртээ цогтой, нүдэндээ галтай”** гэдэгтэй ойролцоо санаат хэлцийг олоорой.
- Залуу насны жаргалыг жаргалд бүү бод
 - Залуудаа сайн явсан нь наслахад мэдэгдэнэ
 - Залуу цагт эцэг эхийн эрхээр
 - Залуу хүн зангасандаа, зандан мод найгасандаа
 - Залуу нас үүлэн чөлөөний наран шиг
7. Эхийн гол санааг илэрхийлсэн холбоо үгийг олоорой.
- Уул тал
 - Тэнгэрийн одон
 - Жихүүн амьсгал
 - Хөгшид өвгөд
 - Монголын залуус
8. Зүйлчилсэн утгаараа бусдаас ялгаатай үгийг олоорой.
- Тал хөндий
 - Өтгөс нялхас
 - Хөгшид өвгөд
 - Жинчин хүн
 - Залуу малчин
9. Эхийн сэдвийг тодорхойлсон өгүүлбэрийг олоорой.
- Уудам талд жинчин хүний дуулах яруу
 - Алсын салхи жихүүн амьсгалаар тас няс хийхэд
 - Идэр залуу малчин түүнийг хураан исгэрнэ.
 - Хөгшид өвгөд галыг базаан хуучин үгийг ярилцана.
 - Монголын залуус нүүртээ цогтой, нүдэндээ галтай
10. **“Өвлийн шөнө тэнгэрийн одон оч мэт гялалзахад...”** гэсэн өгүүлбэрийг найруулгын ерийн зэрэгт хувиргасныг олоорой.
- Өвлийн шөнийн цэлмэг тэнгэрийн түмэн түмэн од хайрлан ширтэнэ.
 - Тэнгэрт одод мяралзан гялалзаж, жихүүн хүйтэн салхи үлээнэ.
 - Өвлийн шөнийн тэнгэрт, одод маш тод харагддаг.
 - Үдшийн тэнгэрт сувдан өнгөт од ганц нэг үзэгдэнэ.
 - Хязгааргүй огторгуйн дунд зугаалсан олон улаан оч оо!
11. Эхэд өгүүлэгчийн дотоод сэтгэлийн ямар үнэлэмж, өнгө аяс илэрсэн бэ?
- Үйл байдал сэтгэлд зохистойг илэрхийлсэн
 - Үйл байдалд санаашран, уйтгарласан
 - Үйл байдлыг тааварлан барагцаалсан
 - Үйл байдлын таагүйг илэрхийлсэн
 - Үйл байдалд эргэлзэж тээнэгэлзсэн
12. **“Өвлийн шөнө тэнгэрийн одон оч мэт гялалзахад Уудам талд жинчин хүний дуулах яруу”** гэдгийн мөр хоорондын холбоосыг солин найруулахад аль нь тохирох вэ?
- мэт
 - тухай
 - шиг
 - улмаас
 - сацуу
13. **“Өндөр газрын хүйтэн тасхийм тасхийм, ясхийм ясхийм ...”** гэдгийг эрдэм шинжилгээний найруулгад зөв хувиргасан хэсгийг олоорой.
- Агаарын температур өгсөх тусам буурдаг тул өндөрлөг газар хүйтэн байдаг.
 - Уулын дээд ба хажуу хэсгийн хөрс нь бэл орчмынхоос залуу байдаг.
 - Өвлийн цагт эх газрын туйлын агаарын масс шилжин ирдэг.
 - Дэлхийн гадарга янз бүр тэнд ирэх дулааны хуваарилалт өөр.
 - Агаар нэг газраас нөгөө газар луу зөөгдөн тасралтгүй хөдөлгөөнд оршдог.
14. Эхэд байгаа **“оч мэт гялалзахад”** гэсэн адилтгасан дүрслэлийн шинжийг олоорой.
- нар шиг
 - ганц нэгээр
 - хурц тод
 - алс холоос
 - жижигхэн
15. Эхээс **“Малууд буцахад...”** гэсэн өгүүлбэрийг дэлгэрүүлсэн үйлийн тодотгол буюу дэд дэлгэрүүлэгч гишүүн өгүүлбэрийг олоорой.
- Малчин түүнийг хураана
 - Бэлчээрт гарсан
 - Өргөн талын хөндий
 - Соргог үсийг гялалзуулан
 - Нүд гялбам мэлцийхэд

16. “Өндөр уулсын оройд будан хүдэн зугаацаад...” гэсэн өгүүлбэрийн нэрийн хамжсан тодотгол гишүүнийг салаалан хувиргасныг олоорой.
 А. хярд В. сүрлэг С. үүл манан D. хөшилдөөд E. хангайн
17. Аль хэсэгт зохиолчийн үнэлэмж, сэтгэлийн өнгө аяс илрээгүй вэ?
 А. Өргөн талын хөндий нүд гялбам мэлцийхэд В. Өвөл, хавар, зун, намрын дөрвөн улирал
 С. Уудам талд жинчин хүний дуулах яруу D. Өвлийн шөнө тэнгэрийн одон оч мэт гялалзахад
 E. Монголын залуус нүүртээ цогтой, нүдэндээ галтай
18. “Уудам талд жинчин хүний дуулах яруу” гэдгийг “Уудам талд жинчин хүний дуулах яруу дуу сонсогдоно.” гэж хувиргавал эхийн найруулгад өөрчлөлт гарах уу?
 А. Дуу сонсогдож байгаа тул оновчтой. В. Баримтын алдаа болно.
 С. Үг дутсан алдаа болно. D. “Яруу дуу сонсогдоно” гэдэг нь учир зүйн алдаа.
 E. Үг илүүдэж шүлгийн айзам хэмнэл алдагдана.
19. Өвлийн улиралд холбогдолгүй хэсгийг олоорой.
 А. Мөнгөн хуяг В. Урьхан салхи С. Жихүүн амьсгал D. Жинчин хүн E. Зургаан мичид
20. Эхэд эсрэг утгатай байгаа үгсийг олоорой.
 А. өндөр уул – өргөн тал В. алсын салхи – алтан дэлхий
 С. мөнгөн хуяг – өвлийн шөнө D. соргог үс – залуу малчин
 E. уул тал – өндөр газар
21. “гялалзуулан” гэдгийн утгат хэсгийг зөв тайлбарласныг олоорой.
 А. гя – идэвхтэй үйл язгуур, үйлийн үндэс
 В. гял - идэвхгүй дуурайх язгуур, нэрийн үндэс
 С. гялалз – идэвхгүй дүрслэх язгуур, жинхэнэ нэр бүтээх дагавар авсан
 D. гялалзуул – үүсмэл үйл үг, үйлдүүлэх хэвд, цагаар төгсгөх нөхцөлтэй
 E. гялалзуулан – үүсмэл үйл үг, үйлдүүлэх хэв, энгийн үйлдэх байдалд, хам холбох нөхцөлтэй
22. Өгүүлбэрийн цэгийн оронд тэмдэг нэрийг тохируулан нөхөөрэй.
Урьхан салхи зөөлнөөр найгаад, агаар цээж дүүрэн амьсгалуулна. (Д.Н)
 А. өглөөний В. зуны С. ариун D. хөндийн E. дэлхийн
23. Дараах хэлзүйн тайлбарт тохирох үгийг олоорой.
 Үйл үг, үүсмэл, өөрөө үйлдэх хэв, энгийн үйлдэх байдалд, цагаар төгсгөх нөхцөлтэй.
 А. нөхөрлөнө В. гялалзуулан С. угтан D. зугаацаад E. буцахад
24. Дараах таван үгээс төрөл биш утгат үгийг олоорой.
 А. гарц В. гарлага С. гарын D. гараа E. гарал
25. Эхийн дараах хэсэгтэй ойролцоо санаат өгүүлбэрийг олоорой.
Хүн бүр өтгөсийг үдэж, нялхсыг угтан
Мянга мянган жил өчүүхэн ч чөлөө завгүй
 А. Хичнээн сайхан салж болмооргүй ертөнц боловч Гэээгтийн дуулдаг өвгөн шувуу шиг буцах цаг болжээ. Жаран хэдэн жил дэлхийн тоос хөдөлгөж их юм үзлээ. Гомдол алга.(С.Э)
 В. Энхрийхэн нялх хүний үр
 Эхийнхээ дуунаас уяатай хөлд орно. (Б.Л)
 С. ...Залуу эцэг өвгөний дэргэд харайлган хүрээд босгох гэж өрөөсөн гараараа өргөхөд нялх хүүхдийн час хийх дуу дахин хадав. Орчлон ертөнц түм буман жил эргэлдсэн хуучин замаараа тэнхлэгээ тойрон эргэсээр... (Д.М)
 D. Энэ хорвоод юунаас урьтаж хүн болоорой гэж эсгий үнэгий чинь хайчлахдаа аав нь бодож суусан. (Б.Л)
 E. Төрсөн газрын шороо эрдэнэ, төрүүлсэн эхийн сүү рашаан. (МАЗ)
26. Дараах өгүүлбэрийн тодруулсан үгсэд хийсэн зөв дүгнэлтийг олоорой.
Металын чөлөөт электрон маш олон тоотойн дээр электрон нь масс багатай байдаг.

- A. Эдгээр нь мэргэжлийн этгээд үг хэллэгийн бүрэлдэхүүнд ордог тул буруу найруулгын жишээ.
- B. Нийгэм эдийн засаг соёлын харилцааны үр дүнд орж ирсэн эдгээр үгсийг заавал орчуулж хэрэглэх шаардлагатай.
- C. Тодорхой нэг мэргэжлийн хүмүүсийн дунд хэрэглэгддэг нэр томъёоны чанартай үг хэллэг тул орчуулахгүй хэрэглэж болно.
- D. Өнөөгийн аман ба бичгийн хэлэнд идэвхтэй хэрэглэгдэхээ больсон хуучин үг хэллэг.
- E. Нийт ард түмний хэлэнд хэрэглэгдэхгүй боловч аль нэг нутгийнхны хэл ярианд өргөн хэрэглэгддэг үгс.
27. Дараах хэсгийн тодруулсан бүтээврийн баймж утгатай хамгийн ойр хэсгийг олоорой.
- Өндөр газрын хүйтэн **масхийм** **масхийм**, ясхийм ясхийм*
- A. Хүйтэн жавар өмнөөс үлээгээд, голын мөс тас няс хагарна. (Д.Н)
- B. Бүрээн дуу тасхийтэл хангинаж, цэргийн жагсаал бэлэн болов.
- C. Бүсгүй тас тас хөхрөхөд шувуу хүртэл дэрхийн нисэв.
- D. Тавхийтэл мориноосоо буун, тасхийтэл жолоогоо сойгоод, тоосонд дарагдсан урд хормойгоороо наранд шарагдсан нүүрийнхээ хөлсийг арчаад ... (Д.Н)
- E. Ангийн хулгайч согооны толгойг тас цавчиж хаяад, нэг хааг нь салгах гэж чухам үсэрч бууж байна. (С.Э)
28. Дараах өгүүлбэрийн утга санааг эсрэг санаагаар солин найруулахад цэгийн оронд дарааллаараа тохирох хэсгийг ол.
- Ухаант хүн ашид өөрийн гэмээ шинжлэх Ухаан... хүн ашид өөрийн гэмээ шинжлэх
- A. маш, үгүй B. гүй, үл C. сайн, эс D. гүй, бөгөөд E. тай, ер
29. Утга төгс өгүүлбэр бүтээхэд, цэгийн оронд аль бүтээвэр нь дарааллаараа тохирох вэ?
- Хаяан ... хурга ишиг майл... ан хөгжим нийл...нэ.**
- A. – аас, - гд, - л B. - руу, - чин, - лд C. – ы, - лц, - лд D.- дахь, - лд, - үүл E.- г, -аар,- ц
30. “- шиг” - ийг төсөөлөн барагцаалах баймж утгаар хэрэглэсэн хэсгийг олоорой.
- A. Өндөр сүмийн орой дээрээс харахад улаан шар хувцастай, ихэс лам нар бор шувуу шиг жижигхэн харагдана. (Б.Р)
- B. Энэ ямар хүн юу хийж байгаа билээ гэж ажиглан ширттэл, нэг хүн сүмийн орой дээрээс доош үсрэх шиг боллоо. (Б.Р)
- C. Олон мянган хүний хөндий цээжнээс ганц хүн шиг санаа алдах чимээ сонстоно.(Б.Р)
- D. Төрийн ёс, хүний ёс хоёр хоорондоо нийлдэггүй үхрийн эвэр шиг хоёр тийшээ чиглэнэ. (Б.Р)
- E. Өтгөн хар хөмсөгтэй бөгөөд бүргэдийн нүд шиг хурц харцтай, цогтой хар нүдтэй. (Б.Р)
31. Дараах хэсэгт хамтрахын тийн ялгалын нөхцөлтэй үг хэд байна вэ?
- Өвөл, хавар, зун, намрын дөрвөн улирал**
Уул, усан, наран, саран лугаа нөхөрлөнө
- A. 2 B. 3 C. 4 D. 5 E. 1
32. Цэгийн оронд зөв бичгийн дүрэм, утгын алдаагүй үгийг нөхөж бичээрэй.
- Би ямаагаа ээждээ тургидаг хөхийг ховлов.**
- A. хураачихаад B. хураачихад C. хураачхаад D. хураачив E.хураачихиад
33. “Алсын салхин жихүүн амьсгалаар тас няс хийхэд...” гэсэн өгүүлбэрт үйлдэхийн тийн ялгалын нөхцөл ямар утгатай байна вэ?
- A. Үйлийн эзнийг заах B. Үйл явдал хам болохыг заах C. Үйлийн багажийг заах
- D. Үйлийн шинж байдлыг заах E. Үйлийн орон зайг заах
34. Ч.Лодойдамба “Тунгалаг тамир” романы Дулмаагийн дүрд тохирох хэсгийг олоорой.
- A. Сайн нэрийг хүсээд олдохгүй, муу нэрийг хусаад арилахгүй
- B. Зориг байвал хэрэг бүтнэ, зорилгодоо хүрэхгүй бол жолоогоо татахгүй
- C. Илжиг ачуулах дуртай, эргүү магтуулах дуртай
- D. Туйлбаргүй хүн буцах нь амар, тугалган жад шантрах нь амар
- E. Хүчтэйгээр ноён болдоггүй, хүсэлтэйгээр баян болдоггүй

ХОЁРДУГААР ХЭСЭГ: ХАРГАЛЗУУЛАХ ДААЛГАВАР

- Санамж:** 1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, хариуг бөглөөрэй.
2. Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноотой

2.1. Хэлцийн утгыг тунгаан цэгийн оронд тохируулан харгалзуулаарай.

- | | |
|---|--|
| a. гэгчээр Данзан, Хүрэл, Дорж хоёроос бие хөлсөө авсан бөгөөд авчирсан зүйлсээ Хүрэлийн тусламжтайгаар борлуулсан ажээ. (Д.Н) | 1. тэмээ хариулсан хүн буурныхаа занг андахгүй |
| b. гэгчээр аманд сул орж байгаа юманд ганц эм хонь ч хаа юм бэ гэж Бадарч дотроо баярлан явжээ. (Ч.Л) | 2. үхсэн буурын толгойноос амьд ат айна |
| c. гэгчээр энэ зүгт жаншлан ажих аваас манай тэнд юу болж байгааг нэгэн өчүүхэн хушуу хэмээн тоохгүй. (Ч.Л) | 3. чоно ойрхондоо ээлтэй |
| d. Их хүрээнээ суух зарлигийн сайд гэгчийн үлгэрээр дэмий л хоосон сүр бадруулахаас өөр чадалгүй болсон цаг билээ. (Б.Р) | 4. аз хүү байвал, ёоз хүүгээр хожно |
| e. Гэвч гэгч хуучны цэцэн үгээр тэрхүү монголчуудын хардаж байсан манж сайдын чих тавин сонсох үг гэрч болж болзошгүй. (Б.Р) | 5. явсан хүн яс зууна |

2.2. Оновчтой харгалзуулан дүрслэх ур маягийг бүтээгээрэй.

- | | |
|-----------|-----------|
| a. Сэмжин | 1. сор |
| b. Мөнгөн | 2. чулуу |
| c. Адуун | 3. үүл |
| d. Ангир | 4. уураг |
| e. Номин | 5. тэнгэр |

2.3. Дараах зохиолуудын төрөл зүйлийг ажиглаж зөв харгалзуулаарай.

- | | |
|---|--------------|
| a. Д. Батбаяр “Цахилж яваа гөрөөс” | 1. Жүжиг |
| b. Д. Пүрэвдорж “Сэгс цагаан Богд” | 2. Шүлэг |
| c. Ц. Дамдинсүрэн “Чемодантай юм” | 3. Тууж |
| d. Д. Нацагдорж “Учиртай гурван толгой” | 4. Найраглал |
| e. Ч. Чимэд “Би монгол хүн” | 5. Өгүүллэг |

2.4. Дараах үгсийг утгын тайлбартай нь зөв харгалзуулаарай.

- | | |
|-----------|---|
| a. Нуга | 1. Нам дор газраас арай өндөрлөг мөргөцөгтэй тэгшдүү газар |
| b. Дэнж | 2. Нуур байгаад хатаж ширгэсэн шаварлаг хөрстэй газар |
| c. Хөндий | 3. Газраас ундрэн гарч хол урсахгүй тогтсон баахан ус |
| d. Бүрд | 4. Хоёр хэсэг уул нуруу мэтийн хоорондуур үргэлжлэн алсалсан тэгш тавиу газар |
| e. Тойром | 5. Хээр буюу голын дагуу байх чийг ихээхэнтэй, ургац сайтай хэсэг газар |